

“ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ”

Х.Уянга

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн дэслэгч, хууль зүйн магистр

КН.Uyanga

University of Internal Affairs School of Law and Social Sciences

Lecturer at the Department of Public Law, Lieutenant of Police, Master of Laws

Хураангуй: Монгол Улс нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид 1990 онд нэгдэн орсноос хойш Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудыг батлан хэрэгжүүлж, хүүхдийн эрх, хамгааллын тогтолцоо, үйлчилгээг бий болгон, салбар бүрийн оролцоог тэгш ханган ажиллахыг зорьж байна.

Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын асуудалд дэлхийн нийтийн түвшинд онцгойлон анхаарч, нийгэм, эдийн засаг, хүмүүний амьдралд шинэ тутамд үүсч буй хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалтай уялдуулан төрийн бодлого, зохицуулалтаа шинэчлэн сайжруулсаар иржээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулиар Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцооны хууль эрх зүйн хүрээг анх удаа үндэсний, орон нутгийн, анхан шатны түвшинд тогтоож, хүүхэд хамгааллын асуудалд олон салбарын оролцоо, чиг үүргийг хуульчилж өгсөн билээ.

Энэхүү илтгэлд Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, Монгол улс дахь өнөөгийн хүүхэд хамгааллын үйлчилгээний бүтэц, Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч талуудын чадавх, нөөцийн хувиарлалт, Хүүхэд хамгааллын тогтолцооны хамтын ажиллагаа, салбар дундын зохицуулалт зэрэг дэд сэдвүүдийн хүрээнд үндэсний болон орон нутгийн нөхцөл байдлыг тодорхойлон гаргасан ач холбогдолтой юм.

Уг судалгааны үр дүнд хүүхдийн эрхийг хангах нь хүүхдийн хөгжил, хамгаалал хариуцсан салбар дангаар шийдвэрлэх асуудал биш бөгөөд салбар бүрт тодорхой түвшинд хамтын ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүгийн бодлого, шийдвэрийг гарган хэрэгжүүлснээр Монгол Улсад хүүхэд хамгаалагдах нөхцөл байдлыг сайжруулахад хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Summary: Since Mongolia joined the United Nations Convention on the Rights of the Child in 1990, it has adopted and implemented laws on children's rights, child protection, child care services, and combating domestic violence.

We aim to work equally. Paying particular attention to the issues of children's rights, development, and protection at the global level, the state policy and regulations have been improved in line with the new needs and situations in society, economy, and human life. The Child Protection Law established the legal framework of Mongolia's child protection system for the first time at the national, local, and primary levels, and legalized the participation and functions of many sectors in child protection issues. In this report, it is important to define the national and local situation within the framework of sub-topics such as violence against children, the current structure of child protection services in Mongolia, the capacity of child protection service providers, allocation of resources, cooperation and interdisciplinary coordination of the child protection system. As a result of this research, ensuring children's rights is not a problem that can be solved by the sector responsible for child development and protection alone, and we believe that cooperation, human resources, budget and financial policies and decisions at a certain level in each sector will contribute to improving the situation of child protection in Mongolia.

Түлхүүр үг: Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрх, олон улсын гэрээ, конвенц, Монгол улс дахь хүүхэд хамгаалах тогтолцоо, хууль эрх зүйн орчин, нийгэм, эдийн засгийн орчин, Нэгдсэн үндэсний байгууллага

Keywords: Child protection, children's rights, international agreements and conventions, child protection system in Mongolia, legal environment, social and economic environment, United Nations Organization

Нэг. Удиртгал

Хүүхэд хамгаалал нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрддэг. Хүүхэд эрүүл, аюулгүй орчинд эцэг эхийн хайр халамжид өсөж бойжих, аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх нөхцлийг бүрдүүлэх хуулийг парламентаас баталсан ч бидэнд шийдэх асуудал байсаар байна. Хүүхдийн эрх гэр бүлийн орчинд хамгийн ихээр зөрчигдөж байгаа нь мэргэжлийн

байгууллагуудын хийсэн судалгаанаас харагдаж байна. Төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд өөр өөрсдийн хүрээнд ажиллаж байгаа ч эцэг, эхчүүдийн үүрэг хариуцлага, ухамсар, ёс зүйг сайжруулах шаардлага зүй ёсоор тулгарч байна. Иймд энэхүү илтгэлд:

1. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл
2. Монгол улс дахь өнөөгийн хүүхэд хамгааллын үйлчилгээний бүтэц
3. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч талуудын чадавх, нөөцийн хувиарлалт
4. Хүүхэд хамгааллын тогтолцооны хамтын

ажиллагаа, салбар дундын зохицуулалт зэрэг асуудал дэвшүүлж шинэ санал санаачилгууд гарна гэдэгт итгэлтэй байна.

ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Хүүхэд хамгаалал нь нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ²¹.

Монгол улсын Үндсэн хууль, иргэний хууль, захиргааны хууль, гэр бүлийн тухай хууль, хөдөлмөрийн тухай хууль, боловсролын тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хууль, зөрчлийн хууль зэрэг хуулиудыг Монгол улсын хэмжээнд хэрэглэж, дагаж мөрдөж байгаа ба нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцуудын дагуу хүүхдийн эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагаагаа явуулахдаа мөрдлөг болгон ашиглаж байна.

Олон улсын түвшинд хүүхдийн эрхийг хамгаалах болсон үйл явдал:

- 1874 он Нью-Йорк 9 настай охины амьдрал "Ан амьтныг

харгислалаас хамгаалах нийгэмлэг" ,

- 1875 он Нью-Йорк "Хүүхдийг харгислалаас хамгаалах нийгэмлэг" байгуулагдаж хамгааллын хөдөлгөөн эхэлсэн ,
- 1927 он Сингапур "Хүүхдийг хэрцгийллээс хамгаалах" хууль ,
- Дэлхийн I, II-р дайны үед Өнчин хүүхдийг асрах, төвлөрүүлэн халамжлах газар
- XIX зууны эцсээр хүүхэд хамгааллын асуудлыг нийгмийн халамжийн хуульд тусгах ажил дэлхий нийтэд эрчимжсэн ,
- 1960 он Америкийн хүүхдийн эмч Кемп " Зодуурт өртсөн хүүхдийн хам шинж" асуудал дэвшүүлсэн ,
- Монголын нууц товчооны 114,119,135,138-р Хүчү, Хөхөчү, Шихихутуг, Борохул нарыг Өэлүн эх асрамжлан өсгөсөн, бусдын нутгаас олж авсан хөвгүүдээ өсгөсөн,
- 13-р зууны эхэн үед Монголын хаан төрийн төлөө зүтгэж амь үрэгдсэн хүний ар гэрт тэтгэвэр өгөх хуультай байсан ,
- 1924 он Анхдугаар үндсэн хуульд тусгасан,

²¹ Хүүхэд хамгааллын тухай хууль

- 1935 он МАХН-ын ТХТ-ийн 10-р тогтоол аж үйлдвэрийн комбинат ажил,
- 1961 он Ардын боловсролын тухай БНМАУ-ын хууль батлагдсан²².

Хүүхдийн эрхийн тухай олон улсын конвенцийн хэрэгжилт.

Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид нэгдэн орсноос хойш манай улс конвенцын хэрэгжилтийн тайлан илтгэлийг таван удаа НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд (ХЭХ) хүргүүлэн, хэлэлцүүлсэн юм.²³ 2017 онд ХЭК-ийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын тавдугаар тайланг хэлэлцээд, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос ирүүлсэн дүгнэлт зөвлөмжид “Хүүхдийн эрхийн тухай конвенци”-ийн мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протоколыг соёрхон баталсан. Мөн хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, Хөдөлмөрийн тухай хууль зэргийг шинэчлэн найруулсныг сайшаасан байна. Илтгэлийг хэлэлцээд²⁴:

- ✓ Хорооны зүгээс нөөцийн хуваарилалт;
- ✓ Хүүхдийн эрх ба бизнесийн салбар;

- ✓ Ялгаварлан гадуурхахгүй байх;
- ✓ Гэр бүлийн орчин;
- ✓ Орчны эрүүл ахуй;
- ✓ Эдийн засгийн мөлжлөг,
- ✓ Хүүхдийн хөдөлмөр,
- ✓ Хурдан морь унаач хүүхдийн асуудалд яаралтай арга хэмжээ авахыг зөвлөсөн.

Үндэсний хууль тогтоомжийн шинэчлэл.

Хүүхэд хамгааллын асуудлаар 2016 оноос хойших эрх зүйн орчны шинэчлэлийн дүнд хүүхэд хамгааллын талаарх ойлголт, нэр томьёо тодорхой болж, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бүх хэлбэрийг мэдээллэх, түүнийг хүлээн авч бүртгэх, тухайн тохиолдолд хариу үйлчилгээ, арга хэмжээг шуурхай үзүүлэх нөхцөл бүрдсэн. Энэ хүрээнд хуулиар чиг үүрэг хүлээсэн төрийн байгууллага, албан тушаалтны хариуцлага тодорхой болсон, тэдний хамтын ажиллагаа ялангуяа хүүхдийн болон цагдаа, хууль сахиулах байгууллагын хүрээнд нэмэгджээ. Үйлчилгээний холбоотой дэд бүтэц буюу түр хамгаалах байр, орчин, ажил үйлчилгээний хөрөнгө төсөв, санхүүжилтийн хэмжээ өмнөхөөс хэд дахин нэмэгдсэн. Хүүхдийн эрхийн улсын байцаагчтай,

²² Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн тогтолцоо

²³ “Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн тогтолцоо” судалгаа. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ хот 2022 он

²⁴ ХЭҮК. 2021. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл. Улаанбаатар

Хүүхдийн элчтэй, Сум, хөдөөгийн багууд Хамтарсан багтай, аймаг, дүүргүүд, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой ажиллах боломж нээгдсэн. Сум, хороо, сургууль, эрүүл мэндийн байгууллага, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх байгууллага, нэгжид нийгмийн ажилтан, сэтгэл зүйч ажиллах, хүүхэд олон цугларах орчинд Сургуулийн Хүүхэд хамгааллын баг, эцэг эхийн зөвлөлүүд ажиллах болж тэдний гол анхааралд хүчирхийллээс сэргийлэх, хариу арга хэмжээ авах асуудалд чиглэж эхэлжээ. Нийгмийн ажилтан мэргэшсэн, чадавхтай байх төдийгүй тэдний ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүргийг Засаг дарга нар хүлээх болсон.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилт

Хүүхэд хамгааллын зөрчил, асуудлыг таних, илрүүлэх, мэдээллэх, бүртгэх, шалгах улмаар хариу арга хэмжээ авч ажиллах үндсэн нөхцөл, түүнд хамтран ажиллах механизм, талуудын үүрэг, оролцоог тодорхойлсон шинэхэн хуулийн хэрэглээ, үр нөлөөг чамлахааргүй байна. Үндэсний болон аймаг, нийслэлийн түвшинд хүүхэд хамгааллын удирдлага хүний болон санхүүгийн нөөц харьцангуй бэхжих, үйлчилгээний хүртээмж нэмэгдэх, ойлголт, хамтын ажиллагааны нэгдмэл байдал дээшилсэн байна. Гэвч анхан шатны нэгжид буюу гэр бүл, хүүхдэд хүрч ажиллан эрсдэлд хүчин зүйлийг бууруулах, урьдчилан сэргийлэх

ажилд хүний болон санхүүгийн нөөц нэмэгдээгүй хэвээр байна.

УИХ-ын Хууль зүйн болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороод хамтран 2019 оны 5 сарын 29 нд Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Ерөнхий хяналтын сонсголыг анх удаа зохион байгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцтай танилцан, холбогдох чиглэл, зөвлөмж гаргажээ. Үйлчилгээний гол механизмын уялдааны талаарх хууль хоорондын зохицуулалт сул, хүүхэд хамгааллын үйл ажиллагаатай холбоотой хуулиудыг дагаж гарсан журмууд нь хүчирхийллийн хохирогч, гэрч хүүхдийг хамгаалахад голлон анхаарснаас хөдөлмөр эрхэлдэг, ялгаварлан гадуурхагдсан зэрэг хүүхэд шаардлагатай үйлчилгээгээ авч чадаж буй нь эргэлзээтэй байна. Зөрчил, дуудлага цагдаагийн байгууллага эсвэл Хүүхдийн тусламжийн утсаар хүлээн авч бүртгэсэн дуудлага, мэдээллээр үйлчилгээний бүртгэл хязгаарлагдаж байна. Үйлчилгээ үзүүлэгч талуудыг магадлан итгэмжилж, стандарт шаардлага, удирдамжийг хэрэгжүүлэх төрийн бус байгууллага, иргэний нийгмийн чадавх бэхжилт орон нутагт удаашралтай байна. НҮБ-ын Хүүхдийн сангийн захиалгаар Корам Интернэйшнл Хүүхэд хамгааллын тухай хуулийн үнэлгээг 2021 онд гүйцэтгэсэн байна. Үнэлгээгээний

тайланд өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтэд олон ахиц дэвшил гарсан ч хүүхэд хамгааллын үйлчилгээ хүртээмжгүй, хүний нөөцийн чадавх сул, санхүүжилт дутмаг, мэдээлэл цуглуулалт болон кейс менежмент хангалтгүй зэрэг олон шалтгаан хуулийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай хэмээн дүгнэсэн байна²⁵.

Хүүхэд хамгааллын холбоотой хуульчилсан актын хэрэгжилт.

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хуульд заасан дараах журмыг баталж хэрэгжүүлж байна. Үүнд:

- ✓ Хүүхдийн эрхийн тухай,
- ✓ Хүүхэд хамгааллын тухай,
- ✓ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг шинээр батлагдсан хуулиудын хэрэгжилтийг дэмжин, хуульд заасны дагуу гарсан олон журмыг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байна.

Хуулиуд батлагдмагц хэрэгжиж эхлэх хугацаа богино байснаас дагалдах журмуудыг эхлэх хугацаа

богино байх нь баримт бичгийн төслийг шуурхай боловсруулах, зарим акт, журмуудыг хэрэглэх талаар сургалт явуулаагүй зэргээс ойлголтын зөрүү үүсэх, гол хэрэгжүүлэгч хамтарсан баг, Хууль зүйн хороодын үйл ажиллагаанд удирдамж, арга зүй, төсөв нөөц дутагдах байдал нөлөөлсөн байдал ажиглагдаж байна. Гэхдээ тодорхой хугацаанд туршиж шалгасан журмуудад үнэлгээ хийх, сайжруулах ажил явагдаж байна.

АСУУДАЛ ДЭВШҮҮЛЭХ НЬ

Хүүхдийн эсрэг

хүчирхийлэл: Тухайлбал ямар нэг хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн байдал 1-14 насны хүүхдийн дунд 47 хувьтай байна. Сүүлийн үед хүүхдүүд интернэт ба цахим орчинд орох нь нэмэгдэж байгаа нь тэднийг цахим-доромжлол, сэтгэл санаа болон бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт, мөлжлөгт өртөх эрсдэлд хүргэж байна. Хүүхдэд чиглэсэн гэмт хэрэг, мөлжлөг, хүчирхийллээс сэргийлж, хариу арга хэмжээ авдаг хүүхэд хамгааллын үр дүнтэй нэгдсэн тогтолцоо байхгүй байна. Хор нөлөө бүхий нийгмийн хэм хэмжээ, арга ажиллагаа өнөө хэр нь оршин байсаар байна²⁶.

²⁵ Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн талаарх ГБХЗХГ-ын 2020 оны тайлангаас

²⁶ ГБХЗХГ.2020. Монголын хүүхдийн байдал: 2019 оны статистикийн эмхэтгэл. Улаанбаатар хот



Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдээс дүрдвал:

- Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр үндэсний бодлогын болон эрх зүйн баримт бичгүүдийг олон улсын хэм хэмжээ, стандартад бүрэн нийцүүлэхэд чиглэсэн бодлогын шинэчлэлүүдийг дэмжих
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээг чухалчлах хэдий ч хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үйлчилгээг загварчлах, өргөжүүлэх, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
- Хүүхэд хамгааллын кейс менежмент, холбон зуучлах үйлчилгээг мэргэжлийн түвшинд хөгжүүлэх, өргөжүүлэх
- Нийгмийн халамж, хууль зүй, эрүүл мэнд, боловсролын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Хүүхэд хамгааллын салбарын хүний нөөцийг чадавхжуулах, улмаар үйлчилгээний чанарыг сайжруулах
- Цахим орчинд бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, дээрэлхэх эрсдэл нэмэгдэж байгааг харгалзан холбогдох байгууллагууд болон мэдээлэл, технологийн компаниудтай хамтран охид, хөвгүүд, өсвөр насныхан, асран хамгаалагчид, мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчдын цахим бичиг үсгийн мэдлэгийг дээшлүүлэхийн тулд бодлого боловсруулах түвшнээс чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг хамруулсан цогц арга хэмжээг хэрэгжүүлэх
- Хүүхдийн эсрэг цахим орчинд болон болон цахим

бус орчинд үйлдэгдсэн хүчирхийллийн талаарх оролцогч талуудын зан үйлийн өөрчлөлтөд нөлөөлөх, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд, тэдэнд үзүүлдэг үйлчилгээ, хүчирхийллийг мэдээлэх механизмын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэхийг дэмжих

- Сургуулийн аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр багш нарын сурган хүмүүжүүлэх эерэг арга барил, чадавхыг хөгжүүлж, бие махбодын шийтгэлийн аливаа хэлбэрийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэх
- Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон болон гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхэд, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээ тогтоолгох гэж байгаа хүүхдэд шүүхээр хамгаалуулах эрхээ эдлэх чадавх, боломжийг нь нэмэгдүүлэхийн тулд эрх бүхий үндэсний байгууллагуудтай хамтрах

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮТЭЦ

Хүүхдийн эрхийн талаарх төрийн бодлого, хөтөлбөр, хууль болон холбогдох журмуудыг баталж үйл ажиллагааны салбар чиглэлүүдээр олон шинэ болох шинэчилсэн бүтэц, зохион байгуулалтууд бий болсон²⁷. Үүнд:

- 2016 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан агентлаг;
- 2016 онд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан агентлагийн дэргэд 108 хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээний төв;
- 2016 онд Монголын нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний болон салбар хороо;
- 2016 онд Нэг цэгийн үйлчилгээний төв;
- 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс;

²⁷ Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал судалгааны тайлан, УБ хот. 2022 он

- 2017 онд 108 хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээний төвийн дэргэд Түр хамгаалах байр;
- 2017 онд Сургалт, судалгаа, мэдээллийн төв;
- 2016 онд Монголын нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний болон салбар хороо;
- 2017 онд Хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх, сурган хүмүүжүүлэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх төв;
- 2017 онд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо;
- 2017 онд Хамтарсан баг;
- 2017 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон дэд зөвлөлүүд тус тус байгуулагдсан байна.

Үндэсний хэмжээний хүүхэд хамгааллын тогтолцооны өнөөгийн зураглалыг доорх байдлаар гаргасан бөгөөд үндэсний хэмжээнд ХНХЯ, ХЗДХЯ, ГБХЗХ, ГХУСЗАА нар тэргүүлэх үүргийг гүйцэтгэж байна. Орон нутгийн түвшин ГБХЗХБ, ГХУСАЗСЗ, нутгийн өөрөө удирдах байгууллага, харин орон нутгийн

түвшинд хамтарсан баг хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх үүргийг хүлээж байна²⁸.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Хүн амын амын хөгжлийн газрын Хүүхэд, залуучууд ахмад настан гэр бүлийн хөгжлийн хэлтэст хоёр мэргэжилтэн хүүхэд хамгааллын асуудлыг хамааран бодлого, зохицуулалтаар ханган ажиллаж байна. Мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтод хүүхдийн эрх, хамгааллын бодлого зохицуулалтыг хангаж ажиллах зорилт, үйл ажиллагааг тодорхойлсон байна. 2021 оны 5 сард тус яамны бүтэц дахин шинэчлэгдэн Гэр бүл, хүн амын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон түүний дор Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтэс бий болгосон байна.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлсэн ХТҮЗ-ийн бүрэлдэхүүнд бүх яамдын дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нар, Олон улсын байгууллагын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл нийт 45 хүн ажилладаг байна. Энэ бүтэц 1995 оноос

²⁸ Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал судалгааны тайлан, УБ хот. 2022 он


хойш ажиллаж байгаа хүүхдэд үр дүнтэй үйлчлэх бүтцийн оновчтой хэлбэр мөн эсэх нь эргэлзмээр.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар.

Хүүхдийн эрхийг хангах бодлогыг хэрэгжүүлэгч үндэсний байгууллагыг Засгийн газрын бүтцэд 1991 онд анх бий болсон бөгөөд 2016 оноос гэр бүл, залуучуудын хөгжлийн асуудлыг нэмж хариуцуулан ЗГХА ГБХЗГ болгон өөрчлөн зохион

байгуулсан. Эдүгээ агентлаг нь орон нутаг, харьяа байгууллагын нийт 1700 гаруй ажилтныг нэгтгэсэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг статустай бодлогын хэрэгжилтийг хангах үндэсний гол механизм болж байна. 2016 онд нийгмийн тухай багц хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор тус агентлагийн чиг үүрэг хэд дахин нэмэгдсэн ч орон тооны хувьд төдийлөн нэмэгдээгүй байна.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын бүтэц, зохион байгуулалт:



Тус байгууллага нь хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, хүүхэд, гэр бүлд

шаардлагатай үйлчилгээ үзүүлэх анхан дунд шатанд ажиллах чиг үүрэг бүхий нэгж, субъект, албан

тушаалтнууд сонгуульт үүрэгтэн, сайн дурын байгууллага, ажилтнууд болон нийгмийн үйлчилгээний болон хууль сахиулах зэрэг талуудын үйл ажиллагааг уялдуулах, хамтын ажиллагааг дэмжих үүрэгтэй.

ГБХЗХГ ажилтнуудын хандлага, мэргэжлийн ур чадвар сул, ажлын байранд тогтворгүй, ойр ойр солигддог төдийгүй улс төрийн нөлөөгөөр удирдлага, мэргэжилтнийг солих хандлага тогтож байна. Улс төрийн нам нөлөөгөөр тус байгууллагын албан тушаалд төрийн албаны мэргэшсэн байдлыг үл харгалзан томилдог нь байгууллагын үйл ажиллагаа, удирдлагын тогтвортой байдал, алсын хараанд сөргөөр нөлөөлж байна. Мөн түүнчлэн, ГБХЗХГ-ын үйл ажиллагааг шинжлэхэд орон нутагт гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан байгууллагын дотоод нэгжүүд ажлын уялдаагүй, ачаалал тэнцвэргүй байна²⁹.

Жишээ нь:

Аймаг, дүүргийн хэлтэст хүүхэд хамгаалал хариуцсан хоёр мэргэжилтэн ажилладгийн нэг нь Улсын байцаагчийн ажлыг давхар хариуцан ажиллаж байна.

Хүүхдийн эрхийн тухай хуульд туссан хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан, ГБХЗХГ-ын нийгмийн ажилтан, орон нутгийн ГБХЗХГ-ын нийгмийн ажилтан, Хүүхдийн эрхийн ажилтан, улсын байцаагч гэсэн албан тушаалын чиг үүргийг нарийвчлах, мэргэжлийн хүнийг тогтвортой ажиллуулах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хүүхэд хамгааллын ажилтны эрүүл мэнд, сэтгэл зүйг хамгаалахын зэрэгцээ хүүхдийн эрхийг хангах ажлын байрны шаардлагын дагуу тасралтгүй сургаж, мэргэшүүлэх, урамшуулж дэмжих, нийгмийн хамгааллыг нь сайжруулах шаардлагатай.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ ТАЛУУДЫН ЧАДАВХ, НӨӨЦИЙН ХУВИАРЛАЛТ

Үндэсний түвшний хүүхэд хамгааллын төсөв: ГБХЗХГ нь хүүхэд хамгааллын үндэсний хэмжээний төсвийн бодлого, санхүүжилт, зарцуулалтыг хариуцдаг байна. Судалгааны явцад улсын хэмжээнд хүүхэд хамгааллын төсөв, санхүүжилтийн зардлын нарийвчилсан дүн, мэдээллийн олдоц, ил тод байдал хангалтгүй

²⁹ ГБХЗХГ.2020. Монголын хүүхдийн байдал: 2019 оны статистикийн эмхэтгэл. Улаанбаатар хот

байв. ГБХЗХГ нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж шилэн дансанд төсвийн зарцуулалтын мэдээллийг тогтмол байршуулдаг хэдий ч хэт ерөнхий, санхүүжилт гаргах тухай тушаалын хавсралтууд дутуу зэргээс хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд зориулж буй төсвийн зарцуулалтыг нарийвчлан тооцох боломжгүй байна.

Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн хүүхдийг хүчирхийллийн эсрэг санаачилга, хүүхэд хамгаалал, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын үр дүнд хүүхдийн хүчирхийллийн эсрэг арга хэмжээний төсвийг эрс нэмэгдүүлж чадсан.

Тухайлбал: Хүүхэд хамгааллын үйлчилгээнд улсын төсвөөс 2017 онд 900 сая төгрөгийг төлөвлөн зарцуулж байсан бол 2018 онд 6.4 тэрбум төгрөг, 2019 онд 7.6 тэрбум төгрөг, 2020 онд 8 тэрбум төгрөг болж 2017 оны түвшнээс 8 дахин нэмэгдсэн байна. Улсын төсвийн нийт зарцуулалтын дийлэнх буюу 43.8 хувь нь ГБХЗХГ-т, 26.1 хувь нь орон нутагт, 23.9 хувь нь Нийслэл, 9 дүүрэгт, 6 хувь нь ХНХЯ -нд тус тус харьяалагдаж байна. Хэдийгээр хүүхэд хамгааллын үйлчилгээнд зарцуулах төсвийн хэмжээг 900 сая төгрөгөөс 8 тэрбумд хүргэж нэмэгдүүлж чадсан хэдий боловч НҮБ-ын Хүүхдийн сангийн тусламжтайгаар хийсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв, зардлын шинжилгээ судалгаанд дурдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн хэмжээнд хүрээгүй хэвээр байна.

Өнгөрсөн хугацаанд хууль эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд гарсан ахиц дэвшил цөөнгүй байгааг салбарын сайд онцлоод салбар бүр хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр анхаарч ажиллах шинэ хандлага, хамтын ажиллагаа бий болсон. Хүүхэд, гэр бүлийн салбарт мөрдөгдөх 50 гаруй дүрэм,

журам, стандартыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хүүхэд хамгааллын

үйлчилгээний зардлыг үе шаттай нэмсэн³⁰.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, төрийн үйлчилгээний бүтэц болгож, программын гуравдугаар шатны шинэчлэлийг хийж, утас, чат, мессежээр дуудлага, мэдээлэл хүлээн авч байна. 2017 оноос хүчирхийллийн хохирогчид аюулгүй байдлын хамгаалалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгжийг тав дахин нэмэгдүүлж, 20 түр хамгаалах байр, 15 нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж байна.

Улсын хэмжээнд 737 хамтарсан багт 6008 гишүүн ажиллаж байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, 30 хорооны 514 гишүүн холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хүүхэд, гэр бүлийн салбарт хүүхдийн эрхийн зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий улсын байцаагчийг бэлтгэж, 36 албан хаагч давхар чиг үүрэгтэй ажиллаж байна. Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын магадлан итгэмжилж, 2018 оноос хүүхэд

хамгааллын үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж эхэлсэн гэв.

Нийгэмд гарч байгаа хүүхдийн эсрэг хүчирхийллийн 70 гаруй хувь нь гэр бүлийн орчинд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс үйлдэгдсэн байна гэсэн юм. Хүүхдийн тусламжийн утсанд 2022 онд 117000 дуудлага мэдээлэл, 2023 оны есөн сарын байдлаар 78310 дуудлага, мэдээлэл хүлээн авсан. 2023 оны 9 сарын байдлаарх хүүхэд хамгааллын 10996 дуудлагын шийдвэрлэлт 61.5 хувьтай байна. Хүүхдийн тусламжийн 108 утасны зорилтот дуудлага 67 хувьд хүрч, иргэд, олон нийт, хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтэн, ажилтнууд, айл хөрш, хүүхдийн зүгээс хүүхдийн эрхийн зөрчлийг мэдээлэх, зөвлөгөө авах төрлийн дуудлага сүүлийн жилүүдэд өссөн гэж байна.

Түүнчлэн цахим орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулах шаардлагатай байгааг салбарын сайд онцлохын зэрэгцээ Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны тайланд хүн амын 99.7

³⁰Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал судалгааны тайлан, УБ хот. 2022он

хувь нь гар утасны хэрэглэгч, интернэт ашиглалт 61 хувь, сошиал медиа хэрэглэгч 78.7 хувь, кибер аюулгүй байдлын индекс 46.5 хувьтай байна. ITU, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжид хүүхдийн өдөрт интернэтэд зарцуулах хугацааг 120 минутаас ихгүй байлгахыг зөвлөдөг. Гэвч 13-18 насны хүүхдийн нийгмийн сүлжээ ашиглахад зарцуулж буй дундаж цаг 231 минут байна. Ялангуяа эцэг, эхчүүд хүүхдээ саатуулах зорилгоор гар утсаа өгч хэрэглүүлдэг бөгөөд энэ нь интернэт, сошиал медиа эрт хэрэглэж эхлэх суурь шалтгаан болж байгааг мэдээлэлдээ дурдсан³¹.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд мэдээлэлдээ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, хамгаалал, асрамж, дэмжлэг, ээлтэй орчин бүрдүүлэх асуудлыг хойш тавилгүй шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байгааг дурдаад

улсын хэмжээнд байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй 11,818 хүүхэд байна³².

Монгол	Улсын
хэмжээнд:	
21 байгууллагын	30
асрамж, халамжийн төв үйлчилгээ үзүүлж, 18 хүртэлх насны 974 хүүхэд, 19-21 насны 86 залуу үйлчилгээ авч байна. Нийт хүүхдийн 8.1 хувь нь буюу 86 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв”-д төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд 130 хүүхэд, Хүүхдийн төв сувилалд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн 19-34 насны хүн өнөөг хүртэл амьдрах тохиолдол байна. БШУЯ-ны мэдээллээр 2022-2023 оны хичээлийн жилд 7171 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд сурч байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг таван аймагт байгуулсан байна.	

³¹ статистикийн эмхэтгэл

³²Засгийн газрын 2022-2023 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн талаарх тайлангаас

МОНГОЛ УЛС ДАХЬ НИЙТ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХЭМЖЭЭНД



2022 онд улсын хэмжээнд 135 сургууль буюу 20,7 хувь нь хүүхэд тээвэрлэх автобустай, 515 сургууль огт автобусгүй байсан бол 2023 оны байдлаар улсын хэмжээнд 292 сургууль хүүхэд тээвэрлэх автобустай болсон байна. Үүнээс төрийн өмчийн 72 сургууль, төрийн бус өмчийн 220 сургууль автобустай. Төрийн өмчийн ерөнхий боловсролын 650 сургуулиас 560 нь гадна камертай, огт камергүй 90 сургууль байх бөгөөд дотор камертай 589 сургууль, огт камергүй ерөнхий боловсролын 61 сургууль байна. Засгийн газрын шийдвэрээр 2022 оноос цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлсэн нь бага насны хүүхдийн хөгжих, хараа

хяналттай байх, эцэг, эх ажлаа хийх боломжийг бүрдүүлснийг салбарын сайд мэдээлэлдээ дурдсан.

2020 онд хийсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр нийгмийн ажлын чадавх сул, мэргэжлийн удирдлага хангалтгүй, кейс менежментийн арга зүйг тодорхой болгоогүй, хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, авах хариу арга хэмжээ, үйлчилгээ хөгжөөгүй, үйлчилгээний зураглал тодорхойгүй, хүний нөөц, санхүүгийн нөөц дутагдалтай, хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийг багтаасан хүүхэд хамгааллын

дигитал мэдээллийн удирдлагын систем хөгжөөгүй зэрэг олон асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгааг тодорхойлсон. Иймд Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуулийн төслийг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулж УИХ-д өргөн мэдүүлэхээр, цаашлаад Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг шинэчлэн найруулахаар ажиллаж, холбогдох судалгаа, шинжилгээг хийж, хэлэлцүүлгүүд өрнүүлж байна гэв.

Хүүхдийн эрх, хамгаалалын асуудалд цаашид авах арга хэмжээний талаар салбарын сайд мэдээлэлдээ, Хүүхэд, гэр бүлийн салбарт хүний нөөцийн тогтвортой байдал алдагдсан, цалин урамшуулал, нийгмийн баталгааны хөтөлбөр хэрэгжүүлэх ажлууд хийгдээгүй өнөөг хүрснийг дурдаад сум, хорооны хамтарсан багийн гишүүдийн 60 гаруй гаруй хувь нь солигдож, зарим хороо, суманд нийгмийн ажилтангүй, хүүхэд, гэр бүлд үйлчилгээ үзүүлэх ажил орхигдож байгааг онцолсон.

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН
ТОГТОЛЦООНЫ ХАМТЫН
АЖИЛЛАГАА,
САЛБАР ДУНДЫН
ЗОХИЦУУЛАЛТ:**

Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал. Боловсролын орчинд хүүхдэд аливаа шийтгэлийн арга хэрэглэх, ялгаварлан гадуурхах, дарамт, хүчирхийлэлд өртүүлэхийг хориглож, хүчирхийллийн асуудлыг илрүүлэх, мэдээлэх, үйлчилгээг дэмжих, хүүхдэд хүчирхийллийн бус харилцааны мэдлэг, ур чадвар олгох, зан үйл нөлөөлөх зэрэг сургалт явуулах, хүчирхийллээс ангид орчин бүрдүүлэх үүрэг зохицуулалтыг Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай зэрэг хуулийн 40 гаруй заалтаар хуульчилжээ. Тиймээс сургалтын байгууллагад суралцаж байгаа хүүхэд бүрийг тухайн орчинд бие мах бодийн шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, 2018 онд ЕБС-ийн хүүхэд хамгааллын бодлого, дотуур байрны орчинд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэн журам,

2020 онд цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого, батлагдсан байна. Эдгээрийг хэрэгжүүлснээр:

- Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хангах;
- Хүүхэд хамгааллын зарчим, ёс зүйг түгээх;
- Эцэг эхэд нөлөөллийн үйл ажиллагаа явуулах;
- Хүүхдийн хамгаалал, аюулгүй байдлыг хангах үйлчилгээ үзүүлэх
- Сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх
- Хүчирхийллээс сэргийлэх үйлчилгээ болон хариу үйлчилгээ
- Эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллийг хүлээн авах, шалгах
- Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах; Нөхцөл байдлын үнэлгээ хийх
- Суралцагчийн эрүүл мэндийн болон сэтгэцийн тулгамдсан асуудлын эрсдэлийн үнэлгээ хийж, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын тусламж үзүүлэх чанар хүртээмж нэмэгдэх боломжтой юм.

Хүүхэд хамгааллын тухай хуулинд боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилтнууд хүүхдийн эсрэг хүчирхийллийг

таамагласан, мэдсэн тохиолдолд заавал мэдээлэх үүрэгтэй. Гэсэн хэдий ч боловсролын салбар сургуулийн нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын ажлыг зохион байгуулах ёстой гэсэн ташаа хандлага түгээмэл байгаагаас багш, бусад ажилтнуудын зүгээс хамгаалал шаардлагатай хүүхдийг нийгмийн ажилтанд даатган үлдээдэг байна. Гэтэл нийгмийн ажилтанд сургуулийн захиргааны ажил, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ, хамтарсан багийн гишүүний ажил гээд дуусашгүй олон ажилтай байдаг бөгөөд тэдэнд хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэжлийн арга зүй дэмжлэг үзүүлдэггүй, аюулгүй байдлыг нь хангах тогтолцоо байхгүй, сургуулийн зүгээс хийж байгаа ажлыг нь ойлгон дэмжих хандлага дутмаг байна.

Хүүхэд хамгааллын тогтолцоон дахь бусад үүрэг хүлээгчдийн адилаар холбогдох ажилтны ажил үүргийн хуваарьт хүүхэд хамгааллын үүрэг ороогүй, дүрэм, журам, стандарт дутмаг, зориулсан төсөвгүйгээс тухайн сургууль хүүхэд хамгааллын чиглэлээр хэр сайн ажиллах нь захирлын мэдлэг, хандлага, туршлагаас бүрэн

хамаарч байна.

Сургуулийн дотуур байранд хүүхдүүд бүтэн жилийн есөн сарыг өнгөрөөдөг бөгөөд энэ хугацаанд хүүхдүүдэд эцэг эх, асран хамгаалагчийн халамж, хараа хяналт байхгүйгээс хүүхдүүдэд олон асуудал тулгардаг байна. Судалгааны ярилцлагаар сургуулийн дотуур байр боловсролын салбарт харьяалагддаг учир хүүхэд хамгааллын ажилтнууд төдийлөн очдоггүй тухай олон удаа дурдагдсан юм.

Цаашлаад МСҮТ-н дотуур байранд хүүхдүүд эцэг эхээс хол, хараа хяналт сул орчинд бие биенээсээ олон муу зүйл сурдаг сөрөг талтай бөгөөд МСҮТ-н дотуур байранд хүүхдийн эрхийг хамгаалах, амьдрах ухаанд сургах хөтөлбөр үйл ажиллагаа явуулдаггүй байна. Хэдийгээр ХНХЯ-ны харьяа боловч МСҮТ болон дотуур байранд нь хамгааллын бодлого байдаггүй, хүүхэд хамгааллын үйлчилгээ орхигдсон талууд хэвээр байна.

Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал. Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан

тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчдад заавал мэдээлэх үүрэг хүлээдэг. Шүүх эмнэлгийн амбулаторийн үзлэг оношлогоо болон лабораторийн шинжилгээ нь насанд хүрээгүй хүнд үнэ төлбөргүй үзүүлэхээр журамласан байдаг. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Нийгмийн эрүүл мэндийн алба 2019-2020 онд НҮБ-н Хүн амын сангийн санхүүжилтээр 10 аймгийн эмч эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдэд “Хүчирхийллийн хохирогчид эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам, түүний дагуу заавал мэдээлэх үүргийн талаарх” сургалтыг тогтмол шат дараалалтай зохион байгуулж байна.

Сургалтын үр дүнд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг ЦЕГ-ын Хүүхэд хамгааллын хэлтэст мэдээлэх журам гарсан. Мөн нийслэлийн дүүргүүдийн эмнэлгийн ажилтнуудад тус сургалтыг зохион байгуулсан нь хохирогч төвтэй үйлчилгээний эхлэл тус салбарт тавигдаж байгаагийн илрэл болсон юм.

Улсын төсвөөс “Хүүхэд хамгаалалд” гэсэн багц үүсгэвэл зүгээр одоогоор тийм зүйл байхгүй. Хүний наймаа, бэлгийн

мөлжлөгийн хохирогч хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний тухайд эмч, ажилтнуудад маш тодорхой мэдлэг мэдээлэл хэрэгтэй байна.

Эрүүл мэндийн салбарт одоогоор хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид, түүний дотор хүүхдэд зориулсан жендерийн мэдрэмжтэй, сэтгэл зүйн засалд чиглэсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ, түүнийг зохицуулсан журам байхгүй байна. Ярилцлагы үеэр эрүүл мэндийн салбарын удирдлагын зүгээс хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд эрүүл мэндийн салбартай хамтын ажиллагааны бэхжүүлэх, эмч мэргэжилтнүүдийнхээ хүүхэд хамгааллын мэдлэг ойлголтуудыг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээтэй гэж үзэж байна.

Иргэний нийгэм, ТББ-ын хамтын ажиллагаа. Судалгааны хүрээнд үндэсний хэмжээнд хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагуудын төлөөллөөс ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага авсан юм. Ярилцлагын үр дүнгээс харахад хүүхэд хамгааллын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-дад нь дараах хоёр нөхцөл байдалд ажиглагдаж

байна. 1990 оноос олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр байгуулагдсан төрийн бус байгууллагуудын хувьд олон улсын байгууллага, төрөөс дэмжлэггүй учраас үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон хэсэг байгууллага байхад өөрийн чадавх, нөөцөд тулгуурлан дотооддоо хөрөнгө босгох, донор байгууллагуудаас төсөл авч хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байгаа төрийн бус байгууллагууд нэмэгджээ. Эдгээр тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын хувьд төрөөс төсвийн дэмжлэг авахгүйгээр төрд хүүхэд хамгааллын үйлчилгээнд бодит хувь нэмэр үзүүлэн, ачаалал үүрэлцэж байгаа юм.

Сүүлийн жилүүдэд олон улсын хэмжээнд хүүхдэд чиглэсэн хувь хүмүүсийн хандив тусламж буурсантай холбоотойгоор донор байгууллагуудын тендер, төсөлд ОУБ үндэсний төрийн бус байгууллагууд өрсөлддөг болсон нь хүний нөөцийн чадавх, үйл ажиллагааны туршлага дутмаг үндэсний төрийн бус байгууллага ОУБ-тай энэ зэрэгцэн өрсөлдөхөд бэрхшээл их байна. Монгол Улсын газар зүйн онцлог, Улаанбаатар дахь хүн амын

төвлөрлөөс шалтгаалан аймаг, сумын түвшинд хүүхэд хамгааллын үйлчилгээ явуулдаг төрийн бус байгууллага бараг байхгүйтэй адил байна. Иймд төрийн бус байгууллагын зүгээс хүүхэд хамгааллын асуудлаар ХНХЯ, ГБХХГ, аймаг/ дүүрэг дэх ГБХЗХХ-ийн үйл ажиллагаанд мэргэжлийн тусламж үзүүлэх, хяналт тавьж, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах тул дээр хангалттай ажиллаж чадахгүй байна³³.

Дүгнэлт:

Монгол улс тусгаар тогтносон, бүрэн эрхт, туурга тусгаар бөгөөд ардчилсан энх тайвны бэлгэ тэмдэг болсон нэгдсэн үндэсний байгууллагын гишүүн улс болохынхоо хувьд конвенц, пакт, протоколыг дагаж мөрдөх ёстой байдаг билээ. Улс үндэсний үнэт зүйл болсон ард иргэд, тэр тусмаа бага насны хүүхдүүдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөхийг таслан зогсоох, түүгээр зогсохгүй тэдгээрийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх нэн тэргүүний зорилго болох билээ. Монгол улсын төр уг үүргээ биелүүлэхдээ хүүхэд хамгааллын бодлого, тогтолцоог тогтмол явуулж буй боловч

хангалттай, бүрэн хэрэгжихгүй байна. Тиймээс энэхүү үйл ажиллагааг сайжруулах, Үндсэн хуульд зааснаар хүүхэд багачуудыг “Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх”-ийн хэрэгжилтэнд өөрийн хувь нэмрээ оруулах үүднээс дараах саналыг дэвшүүлж байна.

Дэвшүүлж буй санал:

1. Анхан шатны нэгжид буюу гэр бүл, хүүхдэд хүрч ажиллан эрсдэлд хүчин зүйлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах
2. Гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогч хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэхэд чиглэн ажиллаж, урьдчилан сэргийлэх ажлыг нэмэгдүүлэх
3. Хүүхэд хамгааллын мэдээллийн удирдлагын систем нь вэб сайтын үйл ажиллагааг сайжруулах
4. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн зөрчил шалгах үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэх
5. Хүүхдийн эрхийг хамгаалах хамтарсан багийн гишүүдийн эрх зүйн орчныг сайжруулах

³³<https://mn.usembassy.gov/wp-content/uploads/sites/192/ADAPT-Full-MNG.pdf>

**Ашигласан эх сурвалжийн
жагсаалт:**

Хууль тогтоомжийн хүрээнд:

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
- Монгол улсын Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016 он
- Монгол улс

Ном сүрах бичгийн хүрээнд:

- Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал судалгааны тайлан, УБ хот. 2022он
- Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн тогтолцоо

Бусад эх сурвалж:

- Хүний эрхийн Үндэсний комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь

илтгэл. Улаанбаатар, 2021. 6 ГБХЗХГ-аас тус судалгаанд өгсөн мэдээллээс

- ХЭҮК. 2021. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл. Улаанбаатар
- ГБХЗХГ.2020. Монголын хүүхдийн байдал: 2019 оны статистикийн эмхэтгэл. Улаанбаатар
- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн талаарх ГБХЗХГ-ын 2020 оны тайлангаас
- <https://mn.usembassy.gov/wp-content/uploads/sites/192/ADAPT-Full-MNG.pdf>